



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/191

Улаанбаатар хот

Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн бодлого, журам, хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6, 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, 30.1.19-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Онцгой байдлын байгууллагын сургалт, бэлтгэлийн бодлого”-ыг нэгдүгээр, “бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэл зохион байгуулах журам”-ыг хоёрдугаар, “бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийг шалгаж үнэлэх заавар, аргачлал”-ыг гуравдугаар, “бие бүрэлдэхүүний сургалтын хөтөлбөр”-ийг дөрөвдүгээр, “хичээлийн хөтөлбөрийн загвар”-ыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан сургалт, бэлтгэлийн бодлого, журам, хөтөлбөр, заавар, аргачлал, загварыг хэрэгжүүлж ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дэд дарга (хурандаа Ц.Уранчимэг)-д даалгасугай.


4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/308 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2025 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн
тушаалын 01 дүгээр хавсралт



ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУРГАЛТ, БЭЛТГЭЛИЙН БОДЛОГО

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн бодлого нь цаашид “сургалт бэлтгэлийн бодлого” гэх Онцгой байдлын байгууллагын хөгжлийн бодлогод нийцүүлэн алба хаагчийг сургаж бэлтгэх, давтан сургах, мэргэжлийн ур чадвар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг дээшлүүлэх, суралцах орчин нөхцөлийг сайжруулах, сургалт бэлтгэлийг зохион байгуулахад баримтлах үндсэн баримт бичиг байна.

1.2. Сургалт, бэлтгэлийг бодлогыг Онцгой байдлын байгууллагын хэмжээнд хэрэгжүүлнэ.

Хоёр. Сургалт, бэлтгэлийн талаар баримтлах зарчим, үндсэн чиглэл

2.1. Сургалт, бэлтгэлийн бодлогын талаар дараах зарчмыг баримтална.

- 2.1.1. Талуудын оролцоонд тулгуурласан байх;
- 2.1.2. Ил тод, тэгш хүртээмжтэй байх;
- 2.1.3. Хэрэгцээ, шаардлагад нийцсэн байх;
- 2.1.4. Хөнгөнөөс хүнд рүү, мэдлэгээс дадлага руу чиглэсэн байх;
- 2.1.5. Харилцан уялдаатай, тасралтгүй байх;
- 2.1.6. Дэвшилтэд технологид тулгуурласан байх.

2.2. Сургалт, бэлтгэлийн бодлого дараах үндсэн чиглэлтэй байна. Үүнд:

- 2.2.1. Гамшгаас хамгаалах мэргэжлийн боловсрол олгох;
- 2.2.2. Бие бүрэлдэхүүнийг төрөл мэргэжлээр давтан сургаж мэргэшүүлэх;
- 2.2.3. Сургалт, бэлтгэлийн үйл ажиллагаанд дэвшилтэт технологийг нэвтрүүлэх;
- 2.2.4. Сургалт, бэлтгэлийг явуулах орчин нөхцөлийг сайжруулах;
- 2.2.5. Сургалт, бэлтгэлийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх.

Гурав. Үндсэн чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1. Гамшгаас хамгаалах мэргэжлийн боловсрол олгох чиглэлийн хүрээнд:

- 3.1.1. Гамшгаас хамгаалах мэргэжлээр офицер, ахлагчийг холбогдох их дээд сургуульд өдөр, эчнээ, гарагийн ангид сургаж бэлтгэнэ;
- 3.1.2. Гадаад, дотоодын их дээд сургуульд алба хаагчдыг нээлттэй сонгон шалгаруулж суралцуулна;
- 3.1.3. Мэргэжил олгох сургалтын хөтөлбөрийг цаг үетэй нь нийцүүлэн шинэчлэх асуудлаар тухайн сургуультай хамтран ажиллана.

Хүрэх үр дүн

Гамшгаас хамгаалах мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэгдэнэ.

3.2 Бие бүрэлдэхүүнийг төрөл мэргэжлээр давтан сургаж мэргэшүүлэх чиглэлийн хүрээнд:

3.2.1.Сургалт бэлтгэлийн хөтөлбөрийг цаг үеийн шаардлагад нийцүүлэн тухай бүр шинэчилж, боловсронгуй болгож хичээлийн хөтөлбөр төлөвлөлтийг нэгдсэн загвараар боловсруулж, сургалт бэлтгэлийг зохион байгуулна;

3.2.2.Алба хаагчдыг төрөл мэргэжлийн дагуу давтан сургаж, мэргэшүүлэх арга хэмжээг төлөвлөж зохион байгуулна;

3.2.3.Дадлага туршлагатай алба хаагчдыг сонгон шалгаруулж, сургагч багшаар бэлтгэх, заах ур чадвар, мэргэшил, арга зүйг дээшлүүлж, алба хаагчид харилцан бие биеэсээ суралцах боломжийг бүрдүүлнэ;

3.2.4.Төв орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, анги байгууллагын ахмадын зөвлөлтэй сургалт бэлтгэл зохион байгуулах чиглэлээр хамтран ажиллана;

3.2.5.Алба хаагчдын дунд мэргэжлийн чиглэлээр тэмцээн уралдаан зохион байгуулах замаар сургалтын чанар, үр дүнг сайжруулна.

Хүрэх үр дүн

Алба хаагчдын мэргэшлийн ур чадвар, чадавх дээшилж, сургалт, бэлтгэлийн хөтөлбөр, төлөвлөлт нь нэгдсэн загвар, шаардлагад нийцсэн бүтэцтэй болж сургалтын чанар дээшилж, Сургагч багш бэлтгэх тогтолцоо бүрдэж, заах арга зүй, ур чадвартай мэргэшсэн боловсон хүчин бүрдсэнээр сургалт бэлтгэлийн хүртээмжтэй байдал нэмэгдэнэ.

3.3.Сургалт, бэлтгэлийн үйл ажиллагаанд дэвшилтэт технологийг нэвтрүүлэх чиглэлийн хүрээнд:

3.3.1.Хиймэл оюун ухаан (AI) дэвшилтэт технологи, нисгэгчгүй нисдэг төхөөрөмж (дрон) зэргийг ашиглаж тактик, оператив, стратегийн түвшинд хариу арга хэмжээг хэрэгжүүлэх чадавхыг бий болгох чиглэлээр сургалтыг зохион байгуулна;

3.3.2.Нисгэгчгүй нисдэг төхөөрөмж, хиймэл оюун ухаан (AI) зэрэг дэвшилтэт технологи ашиглах чиглэлээр гадаад улсад сургаж бэлтгэнэ;

3.3.3.Орчин үеийн дэвшилтэт технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн холбоо байгууллагатай хамтран сургалт бэлтгэлд хиймэл оюун ухаан (AI) нисгэгчгүй нисдэг төхөөрөмж, робот, (VR) төхөөрөмж, зэрэг дэвшилтэд технологийг ашиглана;

3.3.4.Биеэр мэдрэх сургалтын хэрэглэгдэхүүн, үзүүлэн макет ашиглан сургалт зохион байгуулах.

Хүрэх үр дүн

Хиймэл оюун ухаан, нисгэгчгүй нисдэг төхөөрөмж зэрэг технологид суурилсан сургалтын үндэс бүрдэж, мэдээлэл цуглуулах, шийдвэр гаргах чадавх сайжирч, мэргэшсэн боловсон хүчин бүрдэнэ.

3.4.Сургалт, бэлтгэлийн орчин нөхцөлийг сайжруулах чиглэлийн хүрээнд:

3.4.1.Бие бүрэлдэхүүний сурч хөгжих боломжийг хангах, сургалтын гарын авлага, техник хэрэгсэл, номын сан, цахим сургалтын материаллаг баазыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ;

3.4.2.Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын газар, хэлтэс, анги, салбарт сургалт бэлтгэлийн нэгдсэн төв, техник хэрэгсэл, биеийн тамир-чийрэгжүүлэлтийн танхим, сэтгэл зүйн өрөө, сургалт бэлтгэл, дадлагад шаардлагатай орчныг бүрдүүлнэ;

3.4.3.Сургалт, бэлтгэлийн үндсэн хичээлүүдийн цахим сургалтын материал, мэргэжлийн түвшний сорилын эмхэтгэл зэрэг сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулж, сайжруулан шинэчилж, сургалтын үйл ажиллагаанд ашиглана.

Хүрэх үр дүн

Стандартад нийцсэн сургалтын төвүүд байгуулагдаж сургалт, бэлтгэлийн орчин сайжирна.

3.5.Сургалтын нэгдсэн сан бүрдүүлж ашиглах чиглэлийн хүрээнд:

3.5.1.Цахим сургалтын санг алба хаагч бүр хүртээмжтэйгээр ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ;

3.5.2.Сургалт, бэлтгэлийн түвшнийг үнэлэх программыг боловсруулж, албанд нэвтрүүлнэ;

3.5.3.Сургалтад хамрагдсан алба хаагчдын талаарх мэдээллийг цахим системд бүртгэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлнэ;

3.5.4.Мэдээллийн санг алба хаагчдад мэргэжил олгох, гадаад дотоодын мэргэшүүлэх сургалтад хамруулахад ашиглана.

Хүрэх үр дүн

Сургалтын нэгдсэн санг бүрдүүлж, цахим хэлбэрээр хүртээмжтэй ашигласнаар алба хаагч бүрийн сургалтад хамрагдсан байдал, мэргэжлийн ур чадварын ахиц, давтан сургалтын хэрэгцээг бодит мэдээлэлд үндэслэн үнэлэх боломж бүрдэнэ.

Дөрөв. Бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн ангилал

4.1.Бие бүрэлдэхүүнийг сургалт, бэлтгэл дараах ангилалаар зохион байгуулна.

Үүнд:

4.1.1.Алба хаагчдад мэргэжлийн боловсрол олгох сургалт;

4.1.2.Алба хаагчдыг төрөл мэргэжлээр мэргэшүүлэх давтан сургалт;

4.1.3.Бие бүрэлдэхүүний бэлтгэлжилтийн сургалт;

4.1.4.Шинээр томилогдсон алба хаагчийн сургалт.

Тав. Сургалтын арга хэлбэр

5.1.Алба хаагчийг мэргэшүүлэх сургалт нь дараах хэлбэртэй байна.

5.1.1.**Танхимын сургалт** – Тодорхой сэдвийн хүрээнд багш, суралцагчийн оролцоотойгоор хуваарийн дагуу, танхимд суралцагчдад мэдлэг олгох уламжлалт сургалтын хэлбэр;

5.1.2.Цахим сургалт – Техник, технологийн дэвшлийг ашиглан онлайн платформ, цахим системээр дамжуулан сургалтын агуулгыг цахим хэлбэрээр хүргэх, алба хаагч өөрийн цагт тохируулан суралцах боломжтой сургалтын хэлбэр;

5.1.3.Нэгдсэн сургалт, дадлага – Онцгой байдлын байгууллагын төв, орон нутгийн газар хэлтэс, анги салбарын алба хаагчдыг нэгтгэн зохион байгуулж, онолын сургалт болон бодит нөхцөлд ойртуулсан дадлага, сургууль зохион байгуулах хэлбэр;

5.1.4.Танхим, цахим, дадлага хосолсон сургалт – Сургалтын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор танхимын сургалт, цахим сургалт болон дадлага, сургууль зэргийг уялдуулан зохион байгуулах сургалтын хосолсон хэлбэр;

5.1.5.Гадаад, дотоодын туршлага судлах сургалт –Гадаад, дотоодын ижил чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах, харьцуулалт хийх, мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх зорилго бүхий сургалт;

5.1.6.Симуляци, загварчилсан сургалт –Гамшиг осол, аюулт үзэгдлийн нөхцөл байдлыг загварчилж, дуурайлган үзүүлж, оролцогчдыг үүрэг гүйцэтгэх замаар бэлтгэх, хариу арга хэмжээ авах ур чадварыг хөгжүүлэх сургалт;

5.1.7.Дуурайлган үзүүлэх сургалт – Ажил үүргийг гүйцэтгэх арга барил, технологийн үйл ажиллагааг туршлагатай алба хаагчаар үзүүлэн тайлбарлуулж, суралцагчдад дадлагажуулах хэлбэр;

5.1.8.Ажлын байр дээрх сургалт – Алба хаагчдын ажлын байран дээр нь дадлага, зааварчилгаагаар дамжуулан гүйцэтгэлд тулгуурласан мэдлэг, чадвар олгох сургалт;

5.1.9.Бүсчилсэн сургалт – Төв, орон нутгийн Онцгой байдлын газрын алба хаагчдыг бүсчлэн хамруулж, тухайн бүсийн онцлог тохируулан сургалт, дадлагыг зохион байгуулах хэлбэр;

5.1.10.Бие даалтын сургалт – Алба хаагч тухайн чиг үүрэг, сэдвийн дагуу бие даан судалгаа хийж, мэдлэг, ур чадвараа хөгжүүлэх сургалтын хэлбэр.

Зургаа. Зохион байгуулалт

6.1.Онцгой байдлын ерөнхий газрын бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэл хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж нь байгууллагын сургалт, бэлтгэлийг нэгдсэн удирдлагаар хангах, үнэлгээ дүн шинжилгээ хийх, боловсронгуй болгох чиг үүргийг хэрэгжүүлнэ.

6.2.Онцгой байдлын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд сургалтын хөтөлбөр төлөвлөгөөний дагуу сургалт, бэлтгэлийг хамтран зохион байгуулна.

6.3.Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын удирдлага нь сургалт, бэлтгэлийг зохион байгуулж тайлагнана.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2025 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн
тушаалын 04 дугаар хавсралт
А/191

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУРГАЛТ, БЭЛТГЭЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх, хянах, үнэлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.3. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагууд нь бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийг зохион байгуулахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

Хоёр. Зорилго

Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийг зохион байгуулах, алба хаагчдыг бэлтгэх, мэргэжил эзэмшүүлэх, мэргэшүүлэх, хөгжүүлэх сургалтыг зохион байгуулах, сургалт бэлтгэлийн үр дүнг тооцох, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд оршино.

Гурав. Нэр томьёо

Сургалт бэлтгэл - алба хаагч хуулиар хүлээсэн үндсэн үүргийг биелүүлэхэд шаардлагатай мэдлэг, дадлага, чадвар, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлийг эзэмшүүлэх, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын үүрэг гүйцэтгэх бэлтгэл, бэлэн байдлын хангуулахад чиглэгдсэн зохион байгуулалттай, тодорхой зорилго, зорилт бүхий сургалт, бэлтгэлийн цогц үйл ажиллагааг;

Сургалт, бэлтгэлийн зохион байгуулалт - бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн талаар дэвшүүлсэн зорилт, тушаал, шийдвэрийг биелүүлж, болзошгүй гамшгийн цагийн байдлын үед үүрэг гүйцэтгэх бэлэн байдал, жигдрэлтийг хангахын тулд бүх шатны удирдлага, штаб, албан тушаалтнаас сургалтын үйл явцыг төлөвлөх, зохион байгуулах, үнэлэх, шаардагдах материал, санхүүгийн нөөцийг зохицуулах, хянах чиг үүргүүдийг хэрэгжүүлж буй үйл ажиллагааг;

Сургалтын төлөвлөгөө - тухайн төлөвлөгөө ямар агуулгыг хэрхэн судлах, ямар үр дүнд хүрэх, багшийн заах арга зүй, орчин хэрэглэгдэхүүнийг хэрхэн бүрдүүлэх зэргийг төлөвлөсөн баримт бичиг;

Хичээлийн хөтөлбөр - тухайн хичээлээр мэдлэг эзэмшүүлэх, чадвар, хандлага төлөвшүүлэх үйл ажиллагааны зохион байгуулалт, үнэлэх арга зүй, хэрэглэгдэхүүнийг тодорхойлсон баримт бичиг;

Багшийн удирдлага доор явагдах бие даалт – тодорхой асуулгын хүрээнд багшийн удирдлагаар бие даан мэдлэг бүтээх, олж авсан мэдлэгээ цэгцлэх, суралцах арга барил, хандлагаа бие даан бататган сайжруулах зорилго бүхий сургалтын хэлбэр;

Үнэлгээ – мэдлэг чадварыг үнэлэхийн тулд нотлох баримт, материал, мэдээлэл цуглуулж, холбогдох үнэлэлт, дүгнэлт гаргах системтэй үйл явцыг;

Сургалтын цаг - цагийг хэмжих нэгж бөгөөд нэг сургалтын хугацаа нь 45 минут байна. хоёр хичээлийн дунд завсарлагагүйгээр 90 минутад багтаан явуулах үйл явцыг;

Мэргэжил - боловсролын зэрэг эзэмшихэд шаардагдах мэдлэг, чадвар, хандлагын цогцыг;

Мэргэшил - тодорхой мэргэжлийн чиглэлээр нарийн мэргэшсэн, мэргэжлийн өндөр ур чадвар эзэмших үйл явцыг;

Бие даалт - Онцгой байдлын алба хаагч тухайн чиг үүрэг, сэдвийн хүрээнд бие даан судалгаа хийж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх, олж авсан мэдээллээ тайлагнах үйл явц.

Дөрөв. Бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн ангилал

4.1.Алба хаагчдад мэргэжлийн боловсрол олгох сургалт нь холбогдох бусад хууль тогтоомж, сургалтын стандарт, хөтөлбөрийн дагуу гадаад, дотоодын их, дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв болон бусад мэргэжлийн боловсрол олгох сургалтын байгууллагад зохион байгуулах сургалт байна;

4.2.Алба хаагчдыг мэргэшүүлэх, давтан болон төрөл мэргэжлийн сургалт нь алба хаагчдыг тухайн чиг үүрэг, мэргэжлийн шаардлагад нийцүүлэн мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх, гүнзгийрүүлэх, сэргээх, сайжруулах зорилготой байна.

4.4.Бие бүрэлдэхүүний бэлтгэлжилтийн сургалт нь аврах ажиллагаа, гал түймэр, үер ус, химийн осол, газар хөдлөлт зэрэг аюултай нөхцөлд түргэн шуурхай, мэргэжлийн түвшинд ажиллах чадвар эзэмшүүлэх, бодит нөхцөлд ажиллахад бие бялдар, сэтгэл зүй болон техник ашиглах чадварыг хөгжүүлэх сургалт байна;

4.5.Шинээр томилогдсон алба хаагчийн сургалт нь тухайн албан тушаалд томилогдсон алба хаагч тухайн ажлын байранд шууд үр дүнтэй, хариуцлагатай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн анхан шатны сургалт байна.

Тав. Удирдлага, зохион байгуулалт

5.1.Онцгой байдлын ерөнхий газрын бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэл хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж нь сургалт, бэлтгэлийн бодлогын дагуу төлөвлөлт, удирдлага, зохицуулалтын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ, төв орон нутгийн Онцгой байдлын байгууллага, салбар нэгжийн сургалт, бэлтгэлийн явц, үр дүнг хянаж, мэргэжлийн удирдлага зохион байгуулалтаар хангана.

5.2.Онцгой байдлын байгууллагын сургалт, бэлтгэлийг хариуцсан бүтцийн нэгж нь энэхүү журмын 4.2-т заасан сургалтыг тухайн жилд Онцгой байдлын ерөнхий газраас дэвшүүлсэн зорилт, бүтцийн нэгжийн санал, өмнөх оны сургалтын үр дүн, дүн шинжилгээнд үндэслэн төлөвлөж, хэрэгжүүлнэ.

5.3.Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нь энэхүү журам, сургуулийн жилийн удирдамж, төлөвлөгөөг үндэслэн бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг зохион байгуулах тушаал, шийдвэр, сургалт, бэлтгэлийн төлөвлөгөө, хичээлийн хуваарь гарган хэрэгжилтийг зохион байгуулна.

5.4.Бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн удирдамж, төлөвлөгөөг тухайн жил эхлэхээс 14 хоногийн өмнө Онцгой байдлын ерөнхий газрын Сургалт, бэлтгэл хариуцсан бүтцийн нэгж боловсруулж, Онцгой байдлын ерөнхий газрын даргаар батлуулан төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагад хүргүүлнэ.

5.5.Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн жил нь тухайн оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс 12 дугаар сарын 05-ны өдөр хүртэлх хугацаанд үргэлжилнэ. Сургалт, бэлтгэлийн жилийн 02 дугаар сарын хоёр дахь 7 хоногоос 05 дугаар сарын хоёр дахь 7 хоног хүртэл нийт 14 долоо хоногийн хугацаанд үргэлжлэх бөгөөд 1 дүгээр үе буюу эхний хагас гэх, 09 дүгээр сарын эхний 7 хоногоос 12 дугаар сарын эхний 7 хоног хүртэл нийт 14 долоо хоногийн хугацаанд үргэлжлэх бөгөөд 2 дугаар үе буюу сүүлийн хагас байна.

5.6.Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын салбар нэгжийн нийт бие бүрэлдэхүүн, офицер, ахлагч, гэрээт ажилтан, тусгай мэргэжлийн ажилтан алба хаагчид 7 хоногт 1 удаа хичээллэнэ. Нэг өдрийн хичээлийн үргэлжлэх хугацаа 2-4 цаг, сургалтын нэг цагийг 45 минутаар тооцох бөгөөд дундаа завсарлагагүй 90 минутаар үргэлжилнэ.

5.7.Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нар нь бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн агуулга, арга зүй, технологийг боловсронгуй болгох, сургалтын орчин, материаллаг баазыг бэхжүүлэх, алба хаагчийн өөрийгөө хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх ажлыг хариуцаж, сургуулийн жилийн удирдамжийн биелэлт, сургалт бэлтгэлийг зохион байгуулсан тайлан, мэдээ, дүнг сургуулийн жилийн үе бүрийн төгсгөлд болон жилийн эцэст Сургалт, бэлтгэл хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид хүргүүлнэ.

5.8.Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын орлогч дарга, бие бүрэлдэхүүний сургалт хариуцсан албан тушаалтан нь сургалт бэлтгэлийг төлөвлөх, зохион байгуулах, удирдан явуулах, хянах чиг үүргийг хариуцан хэрэгжүүлнэ.

5.9.Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний сургалт хариуцсан албан тушаалтан нь алба хаагчдыг мэргэшүүлэх, бие бүрэлдэхүүний сургалтын арга зүйг боловсронгуй болгох, сургалт бэлтгэлд шинэлэг арга, технологи, туршлагыг нэвтрүүлэх, хичээлүүдийн хөтөлбөр боловсруулах, хичээлийн конспект-төлөвлөгөөг хянаж, удирдлагад танилцуулан баталгаажуулж тайлагнана.

5.10.Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын офицерууд нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хариуцсан бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийг удирдан зохион байгуулж тайлагнана.

5.11.Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагууд бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, цэргийн алба, соёл хүмүүжлийн ажилтай нягт уялдуулан зохион байгуулна.

5.12.Томилгоот ээлжийн буюу 24 цагаар үүрэг гүйцэтгэдэг анги, салбар, бүлгийн дарга, захирагч нь анги, салбарын цагийн хуваарийн дагуу сургалт, бэлтгэл, хичээлийг батлагдсан хөтөлбөр төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.

5.13.Томилгоот ээлжийн сургалтыг 30 хувь танхим, 70 хувь дадлага хэлбэрээр зохион байгуулна.

5.14.Энэхүү журамд заагдаагүй сургалт, бэлтгэлтэй холбогдсон бусад асуудлуудыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарын тушаал, шийдвэрээр зохицуулна.

Зургаа. Сургалт, бэлтгэлийн цаг сэдвийн төрөл

6.1.Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэл нь дараах төрлүүдтэй байна. Үүнд:

6.1.1.Нийт бие бүрэлдэхүүний;

6.1.2.Томилгоот ээлжийн;

6.1.3.Гал түймэр унтраах;

6.1.4.Эрэн хайх, аврах;

6.1.5.Аврагч нохой хөтлөгч;

6.1.6.Улсын нөөцийн салбарын;

6.1.7.Агаараас эрэн хайх аврах;

6.1.8.Гэрээт ажилтны;

6.1.9.Тусгай мэргэжлийн (эмч, сувилагч, оёдолчин, эсгүүрчин, тамирчин, судлаач, эрдэм шинжилгээний ажилтан гэх мэт) төрөлтэй байна.

6.2.Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн төрлүүдээр зохион байгуулах сургалтыг цаг сэдвийн төлөвлөгөөнд нарийвчлан тусгаж зохион байгуулна.

6.3.Журмын 6.1.8, 6.1.9-т заагдсан тусгай мэргэжлийн болон гэрээт ажилтны сургалтын хөтөлбөрийг тухайн нэгжийн үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулж сургалтыг зохион байгуулж болно.

Долоо. Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийн үр дүнг тооцох

7.1.Бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн үр дүнг “Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг шалгаж үнэлэх заавар, аргачлалын”-ын дагуу тооцно.

7.2.Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлд хийсэн хяналт шалгалтын үр дүн, сургуулийн жилд дэвшүүлсэн зорилго, зорилтын хэрэгжилтэд Хяналт шалгалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж хяналт, шинжилгээ хийнэ.

7.3.Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагчийн шийдвэрээр томилогдсон ажлын хэсэг нь сургалт, бэлтгэлийн хяналтын шалгалтыг батлагдсан шалгаж үнэлэх заавар, аргачлалын дагуу сургалт, бэлтгэлийн 2-р үе дууссанаас хойш 14 хоногийн дотор зохион байгуулж дүнг илтгэх хуудсаар баталгаажуулан бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэл хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид албан бичгээр ирүүлнэ.

7.4.Төв орон нутгийн Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэл хариуцсан алба хаагч хөтөлбөр төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан сургалтын мэдээг сургалт, бэлтгэлийн цахим бүртгэл мэдээллийн нэгдсэн санд сургалт зохион байгуулсан тухай бүрд бүртгэнэ.

7.5.Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага, нэгжийн сургалтын ерөнхий дүн нь тухайн алба хаагчийн болон төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага, нэгжийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг дүгнэх үндсэн үзүүлэлтийн нэг шалгуур нь байна.

Найм. Шагнал, урамшуулал, хүлээх хариуцлага

8.1.Бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн зорилго, зорилт, удирдамж, төлөвлөгөөний биелэлтийг хангалттай биелүүлсэн алба хаагчийг шагнаж урамшуулах тухай төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч саналыг үндэслэн нотлох баримтад тулгуурлан шагнаж урамшуулах асуудлыг Онцгой байдлын ерөнхий газар шийдвэрлэнэ.

8.2.Бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн зорилго, зорилт, удирдамж, төлөвлөгөөний биелэлтийг хангалтгүй биелүүлсэн удирдлага, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцно.

---oOo---

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2025 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн
А/191 тушаалын 03 дугаар хавсралт

БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУРГАЛТ, БЭЛТГЭЛИЙГ ШАЛГАЖ ҮНЭЛЭХ ЗААВАР, АРГАЧЛАЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

Бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлд хамрагдсан байдлыг харгалзан мэдлэг, чадварын үнэлгээ нь сургалтын болон хичээлийн хөтөлбөрөөр тодорхойлсон цогц чадамжийн хүрсэн түвшинг тогтооход чиглэх бөгөөд шинжлэх ухааны үндэслэлтэй, бодитой, шударга, ил тод байх зарчмыг удирдлага болгоно.

Хоёр. Шалгалтын арга, хэлбэр, хамрах хүрээ

2.1. Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн бодлого хөтөлбөр, журмыг үндэслэн бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлд хийх шалгалтын ажлыг зохион байгуулна.

2.2. Хүн нэг бүрийн мэдлэгийг аман болон бичгээр (тест), гүйцэтгэх болон даалгавар-ур чадварыг онол болон дасгалаар гэсэн шалгалтын хэлбэрийн аль нэгээр, эсвэл тэдгээрийн хосолсон хэлбэрээр шалгаж үнэлнэ.

2.3. Аман болон бичгээр (тест) авах шалгалтыг урьдчилан бэлдсэн асуултад хариулт авах арга хэлбэрээр авч үнэлнэ. Аслагдсан сум орон нутагт үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдаас амаар болон бичгээр (тест) авах шалгалтыг цахим хэлбэрээр авч болно.

2.4. Амаар авах шалгалт нь өгөгдсөн асуултын хүрээнд онолын болон хэрэглээний тайлбар өгөх, тодорхой тохиолдлыг шийдвэрлэх, шинжилгээ, дүгнэлт, харьцуулалт хийж тайлбарлан ярих хэлбэртэй байна.

2.5. Бичгээр авах шалгалт нь өгөгдсөн асуултын хүрээнд хариулт өгөх чөлөөт бичлэгийн болон тестийн, түүнчлэн бодлого бодох, төсөл боловсруулах, зураглал үйлдэх зэрэг хэлбэртэй байна.

2.6. Шалгалтыг тестээр авах бол нэг сорилд хариулах хугацаа 1 минут (нөхөх, харгалзуулах, асуудал шийдвэрлэх сорилд хариулах хугацааг өөрөөр тогтоож болно), чөлөөт бичлэгийн аргаар авах бол 1 асуултад хариулах хугацаа 15 минутаас багагүй байхаар тус тус тогтооно. Бодлого бодох, төсөл боловсруулах, зураглал үйлдэх хугацааг шалгалтын удирдамжаар тухайлан тогтооно.

2.7. Тодорхой үйлдэл, үйл ажиллагааг биечлэн гүйцэтгүүлэх шалгалт нь дасгал, нормативыг биечлэн гүйцэтгэх, өгөгдсөн нөхцөл байдалд тохируулан мэргэжлийн үйл ажиллагааг удирдах, зохион байгуулах, тодорхой үйлдлийг бие даан болон хамтран гүйцэтгэх, түүний учир холбогдлыг тайлбарлан ярих хэлбэртэй байна.

2.8. Жагсаалын бэлтгэлийн биеэр гүйцэтгүүлэх шалгалтаар хүн нэг бүрийг үнэлж дүгнэхдээ ганцаарчилсан болон салаа, бүлгээр ажиллуулан шалгаж болно.

2.9.Онцгой байдлын ерөнхий газрын даргын нэрэмжит болон сургуулийн жилийн төгсгөлийн шалгалтад бие бүрэлдэхүүний 90-ээс доошгүй хувийг, хяналтын буюу удирдамжийн шалгалтад 60-аас доошгүй хувийг хамруулна.

2.10.Сургалт, бэлтгэлийн хяналтын шалгалтыг тухайн анги, байгууллагын бие бүрэлдэхүүний жагсаалын үзлэгээр эхэлж, нэгдсэн дүнгийн хурлаар дуусгана.

Гурав. Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг шалгаж үнэлэх чиглэл, хугацаа

3.1.Сургалт, бэлтгэлийг дараах чиглэлийн дагуу шалгаж үнэлнэ.

Үүнд:

3.1.1.Бие бүрэлдэхүүний мэдлэг, дадлага- ур чадвар, сэтгэл зүй, бие бялдрын бэлтгэлийг шалгаж үнэлэх;

3.1.2.Албаны болон гамшгийн нөхцөл байдлын үед үүрэг гүйцэтгэх бэлтгэл, бэлэн байдал, жигдрэлтийг шалгаж үнэлэх;

3.1.3.Сургалт бэлтгэлийн хөтөлбөр, төлөвлөгөө, сургуулийн жилд дэвшүүлсэн зорилго, зорилтын хэрэгжилт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг шалгаж үнэлэх.

3.1.4.Сургалт, бэлтгэлийн хяналтын шалгалтыг сургуулийн жилд 1 удаа газар, хэлтэс, анги байгууллагын дарга, захирагчийн тушаалаар томилогдсон ажлын хэсэг энэхүү зааврыг удирдлага болгон зохион байгуулна.

Дөрөв. Бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийг шалгаж, үнэлэх

4.1.Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийг дараах төрлийн хүрээнд шалгаж үнэлнэ. Үүнд:

4.1.1.Нийт бие бүрэлдэхүүний;

4.1.2.Томилгоот ээлжийн;

4.1.3.Эрэн хайх, аврах нохойн;

4.1.4.Улсын нөөцийн салбарын;

4.1.5.Агаараас эрэн хайх, аврах;

4.1.6.Тусгай мэргэжлийн (эмч, сувилагч, оёдолчин, эсгүүрчин, тамирчин, судлаач, эрдэм шинжилгээний ажилтан гэх мэт)

4.1.7.Гэрээт ажилтны сургалт, бэлтгэл

4.2.Сургалт, бэлтгэлийн төрөл тус бүрт үнэлэгдсэн онооны нийлбэр нь тухай салбар, нэгжийн ерөнхий үнэлгээ байна.

Үнэлгээний оноо	Харгалзах үсгэн үнэлгээ	Үнэлгээ	Үнэлгээний шалгуур, болзол
90-100	A	Маш сайн	Цогц чадамжийг бүрэн эзэмшсэнийг илэрхийлнэ. Бие даан мэргэжлийн үйл ажиллагааг чадварлагаар явуулах боломжтой.
80-89,99	B	Сайн	Цогц чадамжийг хангалттай эзэмшсэнийг илэрхийлнэ. Бие даан мэргэжлийн үйл ажиллагааг хэвийн явуулах боломжтой.
70-79,99	C	Хангалттай	Цогц чадамжийг дундаж түвшинд эзэмшсэнийг илэрхийлнэ. Бусдын дэмжлэгтэйгээр мэргэжлийн үйл ажиллагааг явуулах боломжтой.

60-69,99	D	Дутагдалтай	Цогц чадамжийг дунджаас доош түвшинд эзэмшсэнийг илэрхийлнэ. Нэмэлт богино хугацааны сургалтад хамрагдсаны дараа мэргэжлийн үйл ажиллагааг явуулах боломжтой.
0-59,99	F	Хангалтгүй	Цогц чадамж хангалтгүй болохыг илэрхийлнэ. 1 жилээс доошгүй хугацааны сургалтад хамрагдсаны дараа дахин шалгалт өгөх боломжтой.
Шалгалт тасалсан, журам зөрчсөн	FE		Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шалгалт өгөөгүй, шалгалт өгөхөөс татгалзсан, эсхүл шалгалтын явцад тогтоосон журмыг зөрчиж, хуулах хууран мэхлэх арга хэрэглэхийг завдсан болохыг илэрхийлнэ.
Шалгалт хойшлуулсан	E		Хүндэтгэн үзэх шалтгаанаар тухайн өдрийн шалгалтыг хойшлуулсан болохыг илэрхийлнэ.

4.3.Алба хаагч бүрийг бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэл зохион байгуулах журам, хөтөлбөрт заасан хичээлүүдээс 10-аас багагүй хичээл сонгон тухайн сургуулийн жилийн сургалт бэлтгэлээр эзэмшвэл зохих агуулгын хүрээнд шалгаж, тоон болон үсгэн үнэлгээгээр дүгнэнэ. Хичээл тус бүрийн тоон дүнгийн нийлбэрийг тухайн шалгалтад хамрагдсан хичээлийн тоонд харьцуулан алба хаагч бүрийн ерөнхий үнэлгээг гаргана.

4.4.Хичээлийг үнэлэхдээ шалгагдсан алба хаагч тус бүрийн тоон дүнгийн нийлбэрийг тухайн шалгалтад хамрагдсан алба хаагчийн тоонд харьцуулан хичээлийн ерөнхий үнэлгээг гаргана.

4.5.Тухайн алба хаагчийн сурлагын ерөнхий дүнг гаргахдаа шалгагдсан хичээл тус бүр авсан тоон үнэлгээнүүдийг нэмж, хичээлийн тоонд хувааж гаргах бөгөөд сурлагын амжилт, чанарыг хувилж гаргана.

Тав. Хяналтын шалгалтын баталгаажуулалт

5.1.Хяналтын шалгалтын илтгэх хуудсанд дараах үндсэн мэдээллийг тусгана.
Үүнд:

5.1.1.Шалгалтын зохион байгуулалт, хэрэгжүүлсэн арга хэмжээ, онцлог, шалгалт авсан хичээлүүдийн дүн, алба хаагч бүр болон төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын сургалтын амжилт, түүнд хийсэн үнэлэлт, дүгнэлт,

5.1.2.Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын албаны болон гамшгийн цагийн байдлын үед үүрэг гүйцэтгэх бэлтгэл, жигдрэлтийн түвшин,

5.1.3.Сургуулийн жилийн зорилго, зорилт, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн,

5.1.4.Сургалтын орчин нөхцөл, материаллаг баазыг бэхжүүлэх талаар хийсэн ажил, сургалт бэлтгэлээр олсон амжилт, нэвтрүүлсэн тэргүүн туршлага, менежмент, гаргасан алдаа, дутагдал, түүний шалтгаан,

5.1.5.Сургалт бэлтгэлээр дэвшүүлсэн зорилго, зорилтыг хэрэгжүүлсэн байдлыг сургуулийн жилийн I үеийн болон төгсгөлийн үр дүнтэй харьцуулж, дутагдлыг арилгах арга зам, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ

5.1.6.Бусад

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2025 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн
А/191 тушаалын 04 дүгээр хавсралт

